

ИХЭРМӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/122/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
Асуудлыг онцолсон хэсэг.....	4
Аудитын гол асуудал.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.29 № 01/116
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 18,638.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 122,505.4 мянган төгрөгөөр буурахад тайлант онд 45,002.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг батлагдсан төсвийн хурээнд худалдаж авсан, 52,967.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант үед 230,454.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна

Аудитын гол асуудал

Тайлант онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Баянзүрх сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг төлөвлөж, 93.9 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл / төгрөгөөр /
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	265,084,086.08	268,515,553.44
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	18,638,799.21
31210	Төгрөг	-	18,638,799.21
31211	Төрийн сангийн харилцах	-	18,638,799.21
33	АВЛАГА	-	18,638,799.21
33500	Бусад авлага	-	11,672,000.00
33510	Байгууллагаас авах авлага	-	11,672,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ		11,672,000.00
35100	Түүхий эд материал	265,084,086.08	238,204,754.23
35130	Эм боох материал	4,153,483.00	709,120.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,153,483.00	709,120.00
35400	Хангамжийн материал	-	5,994,100.40
35410	Бичиг хэргийн материал	258,540,603.08	229,211,533.83
35420	Аж ахуйн материал	4,616,596.36	1,752,480.00
35440	Түлш, шатах тослох материал	178,206,683.62	178,605,720.22
35450	Барилгын засварын материал	26,310,800.18	2,325,000.00
35460	Хүнсний материал	4,121,300.00	30,000.00
35470	Бусад хангамжийн материал	22,621,390.25	38,390,373.61
35600	Мал амьтад	22,663,832.67	8,107,960.00
		2,390,000.00	2,290,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,252,580,915.25	5,130,075,493.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,252,580,915.25	5,130,075,493.65
39200	Биет хөрөнгө	5,141,045,919.33	5,019,940,496.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,367,954,540.93	5,367,954,540.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(531,559,198.60)	(685,940,018.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,218,750.00)	(6,093,750.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	236,446,524.30	307,353,800.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(97,172,551.43)	(143,894,705.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	155,400,375.16	177,046,943.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(61,727,125.41)	(87,606,453.73)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,489,000.00	5,689,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,505,000.00)	(3,701,800.00)
39217	Ном	59,938,104.38	74,132,939.65
39300	Биет бус хөрөнгө	111,534,995.92	110,134,996.72
39301	Програм хангамж	6,643,745.00	6,643,745.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,108,749.08)	(2,508,748.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	106,000,000.00	106,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,517,665,001.33	5,398,591,047.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,452,467.00	20,720,159.96
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,452,467.00	20,720,159.96
41300	Өглөг	7,452,467.00	20,720,159.96
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	25,367.00	7,003,067.55
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	5,827,392.41
41360	Бусад өглөг	7,427,100.00	7,889,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	7,427,100.00	7,889,700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,510,212,534.33	5,377,870,887.13
51	Засгийн газрын хувь оролцоо	5,510,212,534.33	5,377,870,887.13

51100	Засгийн газрын оруулсан капитал	1,403,305,822.70	-
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,403,305,822.70	-
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	1,403,305,822.70
51200	Хуримтлагдсан үр дүн	3,424,075,473.10	3,291,733,825.90
51210	Өмнөх үеийн үр дүн	3,500,613,119.01	3,420,145,973.10
51220	Тайлант үеийн үр дүн	(76,537,645.91)	(128,412,147.20)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	682,831,238.53	682,831,238.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,517,665,001.33	5,398,591,047.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН / төгрөгөөр /
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,573,951,560.60	1,986,093,807.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,084,681.24	65,720,907.00
120	Нийтлэг татварын бус орлого	86,084,681.24	65,720,907.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,943,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,158,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,785,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	79,894,591.52	52,967,404.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,190,089.72	4,809,803.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,487,866,879.36	1,920,372,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,413,420,000.00	1,763,432,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,763,432,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,413,420,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,959,579.36	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,959,579.36	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,487,300.00	156,940,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,487,300.00	156,940,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,650,489,206.51	2,114,505,954.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,650,489,206.51	2,114,505,954.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,581,652,727.33	2,004,873,418.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,069,298,693.88	1,309,535,588.24
210101	Үндсэн цалин	608,923,358.89	973,631,261.56
210102	Нэмэгдэл	385,123,733.74	237,174,892.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	75,251,601.25	98,729,434.26
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,397,660.00	163,463,800.00
210201	Тэтгэврийн даатгал	98,192,242.98	111,569,496.17
210202	Тэтгэмжийн даатгал	10,349,494.13	13,257,083.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,350,820.44	10,186,297.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,999,286.55	2,532,394.19
210205	Эрүүл мэндийн даатгал	20,505,815.90	25,918,528.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,724,715.94	102,772,392.59
210301	Гэрэл, цахилгаан	16,019,965.94	21,517,392.41
210302	Түлш, халаалт	42,704,750.00	79,255,000.18
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,846,770.00	36,773,129.75

210401	Бичиг хэрэг	1,300,000.00	10,118,466.36
210402	Тээвэр, шатахуун	6,493,670.00	15,236,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	770,200.00	-
210404	Ном, хэвлэл	472,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,238,700.00	457,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,571,800.00	9,123,199.99
210408	Бараа материал акталсны зардал	-	1,837,463.40
2105	Нормативт зардал	63,118,138.25	113,090,807.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,071,080.00	3,873,363.00
210502	Хоол, хүнс	55,047,058.25	108,817,444.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,949,200.00	20,259,800.00
210604	Урсгал засвар	8,949,200.00	20,259,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,101,100.00	-
210702	Дотоод албан томилолт	1,101,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,982,260.00	11,385,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,974,260.00	3,158,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,227,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	215,234,189.26	247,592,200.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,558,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,478,940.00	1,580,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	203,755,249.26	230,454,100.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,836,479.18	109,632,535.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,388,900.00	109,632,535.30
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,885,500.00	92,077,335.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,503,400.00	17,555,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,034.06	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,034.06	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,437,545.12	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,437,545.12	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(76,537,645.91)	(128,412,147.20)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(76,537,645.91)	(128,412,147.20)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,487,866,879.36	1,928,316,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,158,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	3,158,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,158,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,158,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,487,866,879.36	1,925,157,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,413,420,000.00	1,763,432,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,763,432,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,413,420,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,959,579.36	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,959,579.36	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,487,300.00	161,725,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,487,300.00	156,940,000.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	-	4,785,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,451,396,879.36	1,864,675,100.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,451,396,879.36	1,864,675,100.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,383,474,800.18	1,756,753,183.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,069,298,693.88	1,302,557,887.69
210101	Үндсэн цалин	608,923,358.89	966,628,194.01
210102	Нэмэгдэл	385,123,733.74	237,200,259.42
210104	Урамшуулал	75,251,601.25	98,729,434.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,372,293.00	163,463,800.00
210201	Тэтгэврийн даатгал	98,166,875.98	111,012,939.57
210202	Тэтгэмжийн даатгал	10,349,494.13	13,220,260.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,350,820.44	10,461,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,999,286.55	2,614,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,505,815.90	26,154,199.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,989,965.94	72,475,000.00
210301	Гэрэл, цахилгаан	16,019,965.94	15,690,000.00
210302	Түлш, халаалт	44,970,000.00	54,785,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,906,879.36	-
210401	Бичиг хэрэг	1,966,496.36	-
210402	Тээвэр, шатахуун	6,500,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	770,200.00	-
210404	Ном, хэвлэл	77,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,235,583.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,357,600.00	-
2105	Нормативт зардал	64,936,508.00	126,821,446.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,051,400.00	-
210502	Хоол, хүнс	58,624,608.00	126,821,446.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,260,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,527,300.00	15,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,590,000.00	-
210602	Тавилга	1,450,000.00	-
210604	Урсгал засвар	3,487,300.00	15,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,101,100.00	-
210702	Дотоод албан томилолт	1,101,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,448,260.00	12,394,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,440,260.00	3,158,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	9,235,550.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,893,800.00	64,040,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	46,997,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,893,800.00	17,043,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,922,079.18	107,921,917.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,474,500.00	107,921,917.10
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,971,100.00	93,150,717.10
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,503,400.00	14,771,200.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,034.06	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,034.06	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,437,545.12	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,437,545.12	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	36,470,000.00	63,641,499.21
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	36,470,000.00	45,002,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,470,000.00	45,002,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,470,000.00	45,002,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,470,000.00	45,002,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(36,470,000.00)	(45,002,700.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	18,638,799.21
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,638,799.21

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн / төгрөгөөр /
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,403,305,822.70	684,648,775.33	3,498,795,582.21	5,586,750,180.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,817,536.80	1,817,536.80
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,403,305,822.70	684,648,775.33	3,500,613,119.01	5,588,567,717.04
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,817,536.80)	-	(1,817,536.80)
Тайлант үеийн үр дүн	-	-	(76,537,645.91)	(76,537,645.91)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,403,305,822.70	682,831,238.53	3,424,075,473.10	5,510,212,534.33
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,403,305,822.70	682,831,238.53	3,424,075,473.10	5,510,212,534.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,929,500.00)	(3,929,500.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,403,305,822.70	682,831,238.53	3,420,145,973.10	5,506,283,034.33
Тайлант үеийн үр дүн	-	-	(128,412,147.20)	(128,412,147.20)
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,403,305,822.70	682,831,238.53	3,291,733,825.90	5,377,870,887.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр /	
				Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,766,739,900.00	1,747,952,800.79	18,787,099.21	98.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,766,739,900.00	1,747,952,800.79	18,787,099.21	98.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,648,806,500.00	1,640,030,883.69	8,775,616.31	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,241,711,200.00	1,236,557,887.69	5,153,312.31	99.6
210101	Үндсэн цалин	936,903,000.00	907,296,982.01	29,606,017.99	96.8
210102	Нэмэгдэл	258,803,800.00	230,531,471.42	28,272,328.58	89.1
210104	Урамшуулал	46,004,400.00	98,729,434.26	(52,725,034.26)	214.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,213,800.00	155,213,800.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	105,545,400.00	105,402,939.57	142,460.43	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	12,417,100.00	12,560,260.93	(143,160.93)	101.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,933,700.00	9,933,700.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,483,400.00	2,482,700.00	700.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	24,834,200.00	24,834,199.50	0.50	100.0
2105	Нормативт зардал	126,821,900.00	126,821,446.00	454.00	100.0
210502	Хоол, хүнс	126,821,900.00	126,821,446.00	454.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,669,500.00	12,394,250.00	2,275,250.00	84.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,307,000.00	3,158,700.00	148,300.00	95.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,362,500.00	9,235,550.00	2,126,950.00	81.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,390,100.00	109,043,500.00	1,346,600.00	98.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,346,400.00	91,999,800.00	1,346,600.00	98.6

Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,043,700.00	17,043,700.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,933,400.00	107,921,917.10	10,011,482.90	91.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,933,400.00	107,921,917.10	10,011,482.90	91.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	103,162,200.00	93,150,717.10	10,011,482.90	90.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,771,200.00	14,771,200.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,766,739,900.00	1,766,591,600.00	148,300.00	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,763,432,900.00	1,763,432,900.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,763,432,900.00	1,763,432,900.00	-	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,307,000.00	3,158,700.00	148,300.00	95.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,307,000.00	3,158,700.00	148,300.00	95.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,638,799.21	(18,638,799.21)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	88.00	88.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	51.00	51.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	36.00	36.00	-	100.00

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр /	
				Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	156,940,000.00	156,940,000.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,940,000.00	156,940,000.00	-	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,940,000.00	156,940,000.00	-	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,000,000.00	66,000,000.00	-	100.00
210101	Үндсэн цалин	66,000,000.00	59,331,212.00	6,668,788.00	89.90
210102	Нэмэгдэл	-	6,668,788.00	(6,668,788.00)	

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,250,000.00	8,250,000.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	5,610,000.00	5,610,000.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	660,000.00	660,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	528,000.00	528,000.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	132,000.00	132,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,320,000.00	1,320,000.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,690,000.00	67,690,000.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	15,690,000.00	15,690,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	50,000,000.00	50,000,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	15,000,000.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	156,940,000.00	156,940,000.00	-	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	156,940,000.00	156,940,000.00	-	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	156,940,000.00	156,940,000.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36.00	-	-	-
620003	Үйлчлэх ажилтан	36.00	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

2022 онд “Хамтран суралцах үйлээр сайн туршлагаа бий болгон түгээн дэлгэрүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээнд суурилсан хөгжил, оролцооны арга зүйг хэрэгжүүлнэ.” гэсэн зорилт тавьж ажиллажээ.

Сургуулийн захирал Баянзүрх сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг төлөвлөж, 93.9 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг

зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, "хувьсах зардал"-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор "Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн", "Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
 - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"

- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал “ Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу 2021 онд байгууллагын дотоод хяналтын багийг байгуулсан, 2022 онд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсгүүдийг томилж ажиллуулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 119,074.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3
Мөнгөн хөрөнгө		18,638.8	18,638.8
Авлага		11,672.0	11,672.0
Бараа материал	265,084.1	238,204.8	-26,879.3
Үндсэн хөрөнгө	5,252,580.9	5,130,075.5	-122,505.4
Нийт хөрөнгө	5,517,665.0	5,398,591.0	-119,074.0
Богино хугацаат өр төлбөр	7,452.5	20,720.2	13,267.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,510,212.5	5,377,870.9	-132,341.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө / өмчийн дүн	5,517,665.0	5,398,591.0	-119,074.0

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмч данстад өмнөх оноос нэмэгдэж, бараа материал данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 18,638.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 11,672.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2022 оны 12 дугаар сард цахим дэлгүүрээс худалдан авахаар Ай Ти Зон ХХК-тэй гэрээ байгуулж, төлбөр шилжүүлсэн боловч тайлант онд нийлүүлэгдээгүй ухаалаг самбар, он дамжин хэрэгжих сургалтын зардлыг урьдчилан шилжүүлснийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.
3. Бараа материал дансны үлдэгдэл 26,879.3 мянган төгрөгөөр буурахад түлш, шатах тослох материалын дансны үлдэгдэл голлон нөлөөлжээ.
4. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 122,505.4 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд 45,002.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд худалдаж авсан, 52,967.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант үед 230,454.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.
5. Богино хугацаат өр төлбөрийн дүн 13,267.7 мянган төгрөгөөр өсөхөд гэрэл цахилгааны зардал болон хувь хүний орлогын албан татварын өглөг нөлөөлсөн байна.
6. Засгийн газрын хувь оролцоо дансны өөрчлөлтөд тайлант үеийн үр дүн 128,412.1 мянган төгрөг, өмнөх үеийн үр дүнд залруулга хийсэн 3,929.5 мянган төгрөгийн гүйлгээ нөлөөлсөн байна.

7. 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих зардлын дүнг 1,883,852.1 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

УИХ-аар 2022 оны төсвийг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэхээр болсонтой холбоотойгоор байгууллагын төлөвлөж хүргүүлсэн дүнг 510,776.8 мянган төгрөгөөр бууруулан 1,373,075.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр төсвийн хуваарьт дараах байдлаар өөрчлөлт оруулсан байна. Үүнд: БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаал, 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулснаар анхны баталсан төсвийг 390,357.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Ингэснээр нийт төсвийн зарлагыг 1,766,739.9 мянган төгрөгөөр, үүнээс 1,763,432.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 3,307.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Баянзүрх сумын ЗДТГ-т хүргүүлснийг сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 264,277.5 мянган төгрөгөөр баталсан ба төсвийн жилийн дундуур тодотгол хийж, 107,337.5 мянган төгрөгөөр бууруулан, 156,940.0 мянган төгрөгөөр баталсан нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, шимтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 1,763,432.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 156,940.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийт 1,920,372.9 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 3,307.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,158.7 мянган төгрөгийн төвлөрүүлж, 95.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын гүйцэтгэл 100.0 хувьтай, улсын төсвөөс санхүүжих зардал 98.9 хувийн гүйцэтгэлтэй, зарцуулагдаагүй үлдэгдэл 18,638.8 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр байршиж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	4,545.0	4,545.0	-	100.0
2	80312-Сургалт семинар	2,272.5	2,272.5	-	100.0
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	5,226.7	4,465.4	761.3	85.4
4	81801-Үдийн цай хөтөлбөр	103,162.2	93,150.7	10,011.5	90.3
5	81806-Дотуур байрны үйлчилгээ	176,862.4	176,836.4	26.0	100.0
6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	50,950.0	50,364.7	585.3	98.9
7	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	10,226.2	10,226.2	-	100.0
8	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,144,155.3	1,137,044.7	7,110.6	99.4
9	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	266,032.6	265,888.5	144.1	99.9
10	81848-Сурах бичгийн түрээс	3,307.0	3,158.7	148.3	95.5
Дүн		1,766,739.9	1,747,952.8	18,787.1	98.9
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	82,690.0	82,690.0	-	100.0
2	80112-Нийтлэг үйлчилгээ	74,250.0	74,250.0	-	100.0
Дүн		156,940.0	156,940.0	-	100.0
Нийт дүн		1,923,679.9	1,904,892.8	18,787.1	99.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Б.Мядагмаа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,650,489.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 33,009.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 30 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 заалтад заасан Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулах заалт, 15 дугаар зүйлийн 15.2.5 “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;” заалтад зааснаас бусад заалтыг хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй асуудалд зөвлөмж хүргүүлсэн ба тайлангийн 4.4.1 хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

Өмнөх оны өр төлбөрийг барагдуулаагүй асуудалд албан шаардлага хүргүүлсэн болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горимыг баримталж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг бууруулахгүй байх зарчмыг баримтлан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 5 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй, тайлант хугацаанд мэдээлэх 146 мэдээллээс 53 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Мэдээллийн агуулга, үнэн зөв байдлыг шалгахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 681,003.3 мянган төгрөгийн 14 орлогын гүйлгээ, 79,614.4 мянган төгрөгийн 4 зарлагын

гүйлгээ, хөрөнгө, өмч, өр төлбөр үүсгэхтэй холбоотой 47,385.7 мянган төгрөгийн 14 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тендер худалдан авалтын 186,789.7 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;”, заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг таслан зогсоох хугацаатай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг 100 хувь биелүүлж, 1 зөвлөмж хэрэгжилтийн шатанд, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, нийт зөвлөмжийн хэрэгжилт 60.0 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	60.0
Нийт дүн	3	-	3	-	60.0

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөмж хэрэгжилтийн шатандаа явж байгаа бөгөөд боловсролын шинэчлэлтэй холбоотой шинээр гарч байгаа дүрэм, журам, бүртгэлийн онцлогийн талаар нэмж тусгах шаардлагын улмаас батлуулаагүй хүлээгдэж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авч, орлогод авсан эсэх, сургуулийн үйл ажиллагаанд ашиглахаар худалдан авч байгаа сургуулийн удирдлагын цогц системийн ашиглалтад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор баталсан зардлын зориулалт, арга хэмжээ, нормативын дагуу төсвийг тооцон шинжлэхэд 339,259.8 мянган төгрөгийн санхүүжилтийн

илүү тооцоо гарч байна. Энэ нь 2022 онд Засгийн газрын шийдвэрээр багш нарын болон үйлчилгээний ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр баталсан үйлчилгээний ажиллагсдын цалин хөлсийг улсын төсвөөс олгосонтой холбоотой боловч төсвийн төлөвлөлтийг сайжруулахад холбогдох байгууллагууд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Түүнчлэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18,231.2 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар дараах нягтлан бодох бүртгэлийн залруулгыг хийсэн болно. Үүнд:

- Цахим дэлгүүрээс худалдаж авахаар 12 дугаар сард гэрээ байгуулж, төлбөр төлсөн боловч тайлант онд нийлүүлэгдээгүй 9,872.0 мянган төгрөгийн ухаалаг самбарыг орлогод авсныг авлагаар залруулан бүртгэсэн.
- Хөвсгөл аймгийн БШУГ-аас газраас 2019-2021 онд авсан 3,515.3 мянган төгрөгийн түрээсийн сурах бичгийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байсныг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж залруулсан.
- Өмнөх оны өр 1,871.0 мянган төгрөгийг Ням дэвшил ХХК-д шилжүүлж, тайлант оны зардлаар бүртгэснийг өмнөх оны үр дүнд залруулсан.
- Хурцын шил ХХК-д өмнөх оны үдийн цайны өр 914.4 мянган төгрөг шилжүүлж, тайлант оны зардлаар бүртгэснийг өмнөх оны үр дүнд залруулсан.
- Өсөх хишиг ХХК-нд өмнөх оны засварын материалын үнэ 2,058.5 мянган төгрөг шилжүүлж, тайлант оны зардлаар бүртгэснийг өмнөх оны үр дүнд залруулсан.

Аудитаар нийт 1,017,743.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс нийцлийн аудиттай холбоотой 994,793.1 мянган төгрөгийн зөрчилд шилэн дансны хуулийн хэрэгжилтийн асуудлаар, өмнөх оны өр төлбөрийг барагдаагүй, тайлант онд нэмж өр төлбөр үүсгэсэн 20,720.2 мянган төгрөг, өмнөх оны аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй асуудалд зөрчил таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлж, эдийн засгийн ангилал, хөрөнгийн тооллоготой холбоотой 2 зөвлөмжийг өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт

Өмнөх оны өр төлбөрийг барагдуулаагүй, тайлант онд нэмж өр төлбөр үүсгэж, 20720,2 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” Заалтыг хэрэгжүүлээгүй “эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Өр төлбөрийг барагдуулах хугацаатай албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудалд дараах зөвлөмжийг өгсөн. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 2230.0 мянган төгрөгийн автомашины сэлбэг худалдаж авсан нь орон нутгийн төсвөөр зөвхөн байр ашиглалттай холбоотой зардлыг санхүүжүүлэхээр баталсантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- Орон нутгийн болон улсын төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Илрүүлэлт 2:

Байгууллагын нярав солигдоход хөрөнгийн тооллого хийж хүлээлцээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.2 "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нярав, нягтлан бодогч зэрэг эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хөрөнгийн тооллого хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
12 дугаар сард цахим дэлгүүрээс худалдаж авахаар гэрээ байгуулж, төлбөр төлсөн боловч тайлант үед нийлүүлэгдээгүй, биетээр байхгүй ухаалаг самбарыг орлогод авсан.	1	9,872.0			1	9,872.0	1	9,872.0				
Түрээсийн сурах бичгийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн.	1	3,515.3			1	3,515.3	1	3,515.3				
Өмнөх оны өрийг тайлант үеийн зардлаар бүртгэсэн.	3	4,843.9			3	4,843.9	3	4,843.9				
Дүн	5	18,231.2			5	18,231.2	5	18,231.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс			
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хууль, хяналтын байгуулла

Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

									албан шаардлага		гад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон нутгийн төсвийн санхүүжилтээр автомашины сэлбэг худалдаж авсан.	1	2,230.0					1	2,230.0				
Нярав солигдоход хөрөнгийн тооллого хийгээгүй.	1	-					1	-				
Өмнөх оны өр төлбөрийг барагдуулаагүй, нэмж өр төлбөр үүсгэсэн.	1	20,720.2			1	20,720.2						
Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	-			1	-						
Дүн	4	22,950.2			2	20,720.2	2	2,230.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил:								
Шилэн дансны цахим хуудсанд нийт 151 мэдээлэл оруулахаас 5 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй, тайлант хугацаанд мэдээлэх 146 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 7,841.3 мянган төгрөгийн 1 мэдээлэл мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэхтэй холбоотой 5,943.6 мянган төгрөгийн 6 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	994,793.1			1	994,793.1		
Дүн	1	994,793.1			1	994,793.1		



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 27 өдөр

№ 29/2023-0439/ХГА-2023/122
/НН-СТА-ТЦЗ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 146 мэдээлэл байршуулахаас 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 760,617,700 (Долоон зуун жаран сая зургаан зуун арван долоон мянга долоон зуу)-н төгрөгийн 18 гүйлгээ, хөрөнгө, өмч, өр төлбөр үүсгэхтэй холбоотой 47,385,700 (Дөчин долоон сая гурван зуун наян таван мянга долоон зуу)-н төгрөгийн 14 шийдвэр, тендер худалдан авалтын 186,789,700 (Нэг зуун наян зургаан сая долоон зуун наян есөн мянга долоон зуу)-н төгрөгийн 2 мэдээлэл, нийт 994,793,100 (есөн зуун ерэн дөрвөн мянга долоо зуун ерэн гурван мянга нэг зуу)-н төгрөгийн 53 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.
2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.3-д "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;" 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг гүйцэтгэгч Д.Түвшинбаяр, нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЯМ





ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 27 өдөр

№ 28/АЭЭБД-439/ХАА-2023/022
НА-СТА-1143

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өмнөх онд үүссэн өр төлбөр 7,452,000 (долоон сая дөрвөн зуун тавин хоёр мянга)-н төгрөгийг барагдуулаагүй, тайлант жилд 13,268,200 (арван гурван сая хоёр зуун жаран найман мянга хоёр зуу)-н төгрөгийн өр төлбөр нэмж үүсгэсэн байна.
2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих.”, 16.5.4 “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй”, 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно” гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Үүссэн өр төлбөрийг барагдуулж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг гүйцэтгэгч Д.Түвшинбаяр, нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043